



НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/103

Улаанбаатар хот

Налайх дүүргийн Засаг даргын Тамгын  
газрын данс бүртгэлээс тээврийн хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/61 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Ашиглалтын шаардлага хангахгүй болж, засаж сэлбэх нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлж худалдахаар шийдвэрлэгдсэн 9,900,000 (есөн сая есөн зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий Хьундай соната-5 06-01 УНЦ улсын дугаартай тээврийн хэрэгслийг акталж, данс бүртгэлээсээ хасахыг Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар (Ж.Алтангэрэл)-т зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслийг Нийслэлийн Өмчийн Харилцааны газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар (Ж.Алтангэрэл)-т үүрэг болгосугай.

3.Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс (Б.Батбаяр)-т даалгасугай.

4.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М. БАЯРАА

115050000295